



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ  
БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 10 сарын 04 өдөр

Дугаар А/160

Бат-Өлзий сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.1, 17.1.2, 26 дугаар зүйлийн 26.1 дэх хэсэг, аймгийн Засаг даргын 2022 оны 09 дүгээр сарын 26-ны өдрийн “Улсын үзлэг, тооллого байгуулах тухай” А/441 дүгээр захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумын нутаг дэвсгэр дэх түүх, соёлын үл хөдлөх дурсгалын улсын үзлэг, тооллогыг зохион байгуулах ажлын хэсэгтэй хамтран ажиллах сумын ажлын хэсгийг дараахь бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Д.Очирбат (Соёлын төвийн дарга)  
Нарийн бичгийн дарга: Г.Хорол-Эрдэнэ (Орон нутаг судлах танхимын ажилтан)

Гишүүд: И.Маралмаа (Газрын даамал)  
Б.Янжиндулам (Байгаль орчны хяналтын улсын байцаагч)  
Багийн Засаг дарга нар  
Н.Засарзүсэм (Цагдаагийн тасгийн Экологийн цагдаа)  
Тухайн дурсгалыг хамгаалагч иргэн

2. Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын улсын тооллогыг үр дүнтэй зохион байгуулж, тайлан мэдээг холбогдох газарт хугацаанд нь тайлагнахыг ажлын хэсгийн ахлагч (Д.Очирбат)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

С.АМГАЛАН